



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

IX ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2021 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 18:30 цагт Төрийн ордонд 92.5 хувийн ирцтэй хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Коронавируст халдвар /Ковид19/-ын нөхцөл байдлын мэдээлэл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;

*Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд,*

2. Нийслэлийн хэмжээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх танилцуулга;

*Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга
Б.Бямбадорж,*

3. Эрдэмтдийн зөвлөлийн санал, дүгнэлт;

*Эрдэмтдийн зөвлөлийн дарга,
Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн захирал, доктор, профессор
Н.Хүрэлбаатар,*

4. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах эсэх талаар;

*Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
бригадын генерал Г.Ариунбуян*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Зам, тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,

Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын захирагч,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, Т.Гантулга нарт:

1.1. Нийслэл хотод халдварын тохиолдол нэмэгдэж байгаатай холбогдуулан “Улбан шар” түвшинд хязгаарлалт тогтоохгүй үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний байгууллагуудын цагийн хуваарьт зохицуулалт хийх;

1.2 Улаанбаатар хотоос орон нутагт халдвар тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлээс гарах хүн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хатуу хяналт тавих, зайлшгүй шаардлагаар орон нутагт зорчих иргэдийг PCR шинжилгээний хариуг үндэслэн хурдан шуурхай зохин байгуулах;

1.3. Амралтын өдрүүдэд зарим үйлчилгээний газруудыг ажиллуулахгүй байх;

Хоёр. Улсын онцгой комиссын гишүүд,
Агентлагийн дарга нарт:

2.1. Нийслэл хотод халдварын эрсдэл өндөр байгаатай холбогдуулан төрийн байгууллагын ажилтан, /иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээг тусгай дэглэмээр/ албан хаагчдыг ажил үүргээ зайнаас гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх;

2.2. Аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг цахимаар ажиллуулах;

Гурав. Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд,

Шуурхай штабын дарга, хурандаа Ж.Чүлтэмсүрэн нарт:

3.1. Халдварын тохиолдол нэмэгдэж байгаатай холбогдуулан орны нөөц бүрдүүлэх, эмчилгээний явуулын баг, тандалтын багийн хүн хүчний тоог нэмэгдүүлэх;

3.2. Эм, эмийн хэрэгслийн нөөц, хамгаалах хувцас хэрэгслийг нэмэгдүүлэх;

- 3.3. Суурин болон хөдөлгөөнт хүчил төрөгчийн нөөцийг нэмэгдүүлэх;
- 3.4. Эмчилгээ, оношлогооны хүчин чадлыг нэмэгдүүлэх;
- 3.5. Зорилтот бүлэгт чиглэсэн арга хэмжээг авч ажиллуулах;

Дөрөв . Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга, Улсын онцгой комиссын гишүүн Ц.Ганзориг,

Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд нарт:

- 4.1. Вакцинжуулалтын талаарх ойлголтыг иргэд олон нийтэд нээлттэй зөв, нэг урсгалаар давтамжтай хүргэх;
- 4.2. Вакцинжуулалтын ажлыг хуваарийн дагуу тасралтгүй шуурхай зохион байгуулж, ажиллах

Тав . Эрдэмтдийн зөвлөлийн дарга, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн захирал Н.Хүрэлбаатар,

Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, Улсын онцгой комиссын гишүүн, хурандаа Ж.Амгалан нарт:

- 5.1. Салбар, салбарын мэргэжилтнүүдээс бүрдүүлсэн эрдэмтдийн багийг байнгын үйл ажиллагаанд оруулж, цаг үеийн нөхцөл байдлын талаар өдөр бүр, 7 хоног тутам үнэлгээ хийж, дүгнэлт санал бэлтгэж, Улсын онцгой комисст танилцуулах, олон нийтэд цаг үеийн асуудлаар тогтмол олон давтамжтай мэдээ мэдээллийг хүргэж ажиллах;
- 5.2. Иргэд, олон нийтэд чиглэсэн зөвлөмж гаргах;

Зургаа. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар,

Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, Улсын онцгой комиссын гишүүн, хурандаа Ж.Амгалан,

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал Н.Цогбадрах нарт:

- 6.1. Нийслэлийн хэмжээнд халдваргүйжүүлэлтийн ажлыг өргөн хүрээнд зохион байгуулж, хатуу хяналт тавьж ажиллах;
- 6.2. Иргэд гэр бүлээрээ агаар салхинд гарах, ууланд явах зэрэг идэвхитэй хөдөлгөөнийг дэмжих;

Долоо. Тагнуулын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, хурандаа П.Одонбаатар,

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд нарт:

7.1. Халдварт цар тахал, вакцинжуулалтын талаар цахим орчинд гарч буй худал мэдээллүүдийг тухай бүр шуурхай шалгаж, иргэд олон нийтэд мэдээллэх;

7.2. Халдварт өвчин судлалын үндэсний төв, Энхсаран сувилал, Баянзүрх дүүргийн Нэгдсэн эмнэлгийн ажилтан, алба хаагчдын гаргасан ноцтой зөрчил, дутагдлыг хууль, тогтоомжийн хүрээнд шуурхай шалгаж, танилцуулах;

Найм. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганбат,

Улсын онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбүян,

Улсын онцгой комиссын гишүүд, Аймаг, нийслэлийн онцгой комиссын дарга нарт:

8.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор бүх аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал сунгах;

8.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор хилийн бүх боомтоор улсын хил нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг зогсоосон хугацааг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал сунгах асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулах;

Ес. Боловсрол, шинжлэх ухааны сайд, Улсын онцгой комиссын гишүүн Л.Энх-Амгалан,

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Улсын онцгой комиссын гишүүн А.Ариунзаяа,

Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд нарт:

9.1. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх болон их, дээд сургуулийн төгсөх ангийн оюутны дадлага, лабораторийн хичээлийг тус тус сургуулийн орчинд халдвар хамгааллын дэглэм баримтлан танхимаар зохион байгуулах;

9.2. Гадаад улс орны их, дээд сургууль, коллежид суралцах иргэдийн хэлний чадамжийг үнэлэх, мэдлэгийн түвшин тогтоох олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгалт авах төв, анги танхимын тоог нэмэгдүүлэх;

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, хурандаа Ж.Амгалан, Шуурхай штабын дарга, хурандаа Ж.Чүлтэмсүрэн нарт даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХУРАНДАА

Ж.АМГАЛАН

--o0o--